



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/03

Мандалговь

Ажил хүлээлцэх комисс томилох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.6 дахь заалт, тус Газрын дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ажилд томилогдсон Төмөрийн Саранчимэгийн ажлыг хүлээлцэх комиссыг томилсугай.

Комиссын дарга: Б.Батхүү (Аялал жуулчлал, гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: М.Мөнхзул (Мэдээллийн сан, байгаль орчны төлөв байдал, сургалт сурталчилгаа, төсөл хөтөлбөр, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

А.Мөнх-Эрдэнэ (Биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар нутаг, төрийн бус байгууллага, хариуцсан мэргэжилтэн)

А.Нэргүй (Ерөнхий нягтлан бодогч)

С.Хишигжаргал (Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав)

2. Ажил үүрэг гүйцэтгэх зорилгоор олгосон аливаа ажлын багаж төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хөрөнгө, бичиг баримт, ажил үүргийн дагуу бүрдүүлсэн хувийн хэрэг, холбогдох бусад зүйлийг 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн дотор нэг бүрчлэн хүлээлгэн өгч акт үйлдэхийг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Н. ГАНТУЛГА

